



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/043/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ТАВДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Р.ЦОЛМОН ТАНАА

2026.02.28 № СЭА-2026/043/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мандал сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 31,236.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	295,271,108.94	429,116,079.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		295,271,108.94	429,116,079.07
3121	Төгрөг		295,271,108.94	429,116,079.07
31211	Төрийн сангийн харилцах		295,271,108.94	429,116,079.07
35	БАРАА МАТЕРИАЛ	6	93,047,099.05	129,436,899.05
351	Түүхий эд материал		13,806,798.37	19,630,198.37
3511	Тусгай зориулалттай материал		13,806,798.37	19,630,198.37
354	Хангамжийн материал		79,240,300.68	109,806,700.68
3541	Бичиг хэргийн материал		544,200.00	217,200.00
3542	Аж ахуйн материал		541,400.00	183,300.00
3544	Түлш, шатах тослох материал		216,000.00	
3546	Хүнсний материал		2,771,900.00	86,400.00
3547	Бусад хангамжийн материал		75,166,800.68	109,319,800.68
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		388,318,207.99	558,552,978.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	2,190,527,680.72	2,431,212,527.55
392	Биет хөрөнгө		2,064,247,680.72	2,305,262,527.55
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,673,000,000.00	1,673,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(78,944,444.38)	(111,611,111.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		270,039,753.94	301,221,453.94
39206	Хуримтлагдсан элэгдэл		(77,194,243.17)	(131,295,059.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		178,573,200.00	203,080,950.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(79,114,497.25)	(115,997,346.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө		193,358,300.00	503,602,102.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(20,789,295.62)	(31,420,683.61)
39217	Ном		5,318,907.20	14,682,221.36
393	Биет бус хөрөнгө		126,280,000.00	125,950,000.00
39301	Програм хангамж		1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(770,000.00)	(1,100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		125,400,000.00	125,400,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,190,527,680.72	2,431,212,527.55
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,578,845,888.71	2,989,765,505.67
51	Засгийн газрын хувь оролцоо		2,578,845,888.71	2,989,765,505.67
512	Хуримтлагдсан үр дүн		2,578,845,888.71	2,989,765,505.67
5121	Өмнөх үеийн үр дүн		2,578,845,888.71	2,578,845,888.71
5122	Тайлант үеийн үр дүн			410,919,616.96
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,578,845,888.71	2,989,765,505.67
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,578,845,888.71	2,989,765,505.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,958,813,287.07	2,436,590,819.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,867,522,900.00	2,378,235,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,867,522,900.00	2,378,235,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		91,290,387.07	58,355,319.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		91,290,387.07	58,355,319.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		74,078,265.70	371,999,946.16
120	Нийтлэг татварын бус орлого		74,078,265.70	371,999,946.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		8,177,400.00	2,035,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,577,400.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,600,000.00	2,000,980.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		59,604,907.90	336,395,866.16
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		6,295,957.80	33,568,100.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	2,032,891,552.77	2,808,590,766.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,908,111,676.82	2,397,671,149.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,809,112,096.82	2,231,270,699.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,354,298,523.01	1,751,719,385.95
210101	Үндсэн цалин		863,840,680.45	1,053,208,905.76
210102	Нэмэгдэл		427,207,956.06	556,567,271.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт			49,769,563.94
210104	Урамшуулал		63,249,886.50	92,173,645.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		160,667,867.63	206,766,599.19
210201	Тэтгэврийн даатгал		108,823,364.00	141,848,960.11
210202	Тэтгэмжийн даатгал		13,162,350.11	17,719,271.75
210203	ҮОМШӨ-ний даатгал		6,867,660.95	9,871,072.26
210204	Ажилгүйдлийн даатгал		6,363,038.53	7,454,936.09
210205	Эрүүл мэндийн даатгал		25,451,454.04	29,872,358.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		33,181,787.07	44,815,699.97
210301	Гэрэл, цахилгаан		15,670,777.07	18,506,869.97
210302	Түлш, халаалт		15,909,000.00	23,541,280.00
210303	Цэвэр, бохир ус		1,102,010.00	2,167,550.00
210304	Байрны түрээс		500,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,316,300.00	
210408	Бараа материал акталсны зардал		2,316,300.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		57,892,600.00	6,243,870.00
210604	Урсгал засвар		57,892,600.00	6,243,870.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		21,884,409.55	29,568,852.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,337,400.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		20,547,009.55	29,328,852.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		178,870,609.56	192,156,291.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		45,696,356.00	39,178,922.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		13,839,700.00	12,615,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		119,334,553.56	140,361,819.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		98,999,580.00	166,400,450.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		98,999,580.00	166,400,450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		81,396,180.00	146,089,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,603,400.00	20,311,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,908,111,676.82	2,397,671,149.17
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		124,779,875.95	410,919,616.96
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)			
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		124,779,875.95	410,919,616.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,966,990,687.07	2,438,626,799.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,177,400.00	2,035,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,177,400.00	2,035,980.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,177,400.00	2,035,980.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,577,400.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,600,000.00	2,000,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,958,813,287.07	2,436,590,819.97
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,867,522,900.00	2,378,235,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,867,522,900.00	2,378,235,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,290,387.07	58,355,319.97
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,290,387.07	58,355,319.97
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,802,447,133.26	2,260,131,029.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,802,447,133.26	2,260,131,029.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,126,443.26	2,096,416,079.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,354,298,523.01	1,751,719,385.95
210101	Үндсэн цалин	863,840,680.45	1,053,208,905.76
210102	Нэмэгдэл	427,207,956.06	556,567,271.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт		49,769,563.94
210104	Урамшуулал	63,249,886.50	92,173,645.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,667,867.63	206,766,599.19
210201	Тэтгэврийн даатгал	108,823,364.00	141,848,960.11
210202	Тэтгэмжийн даатгал	13,162,350.11	17,719,271.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,867,660.95	9,871,072.26
210204	Ажилгүйдлийн даатгал	6,363,038.53	7,454,936.09
210205	Эрүүл мэндийн даатгал	25,451,454.04	29,872,358.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,397,787.07	44,599,699.97
210301	Гэрэл, цахилгаан	15,670,777.07	18,506,869.97
210302	Түлш, халаалт	16,125,000.00	23,325,280.00
210303	Цэвэр, бохир ус	1,102,010.00	2,167,550.00
210304	Байрны түрээс	500,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,892,600.00	13,755,620.00
210604	Урсгал засвар	57,892,600.00	13,755,620.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,744,409.55	29,568,852.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,337,400.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,407,009.55	29,328,852.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,125,256.00	50,005,922.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,875,856.00	37,347,972.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,249,400.00	12,657,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,320,690.00	163,714,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,320,690.00	163,714,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,717,290.00	143,403,950.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,603,400.00	20,311,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	164,543,553.81	178,495,770.13
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,694,900.00	44,650,800.00
	Дотоод эх үүсвэрээр	37,694,900.00	44,650,800.00
222001	Тоног төхөөрөмж	28,298,900.00	24,884,300.00
223001	Бусад хөрөнгө	9,396,000.00	19,766,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,694,900.00)	(44,650,800.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	126,848,653.81	133,844,970.13
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		295,271,108.94
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		429,116,079.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,578,845,888.71	2,578,845,888.71
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			410,919,616.96	410,919,616.96
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,989,765,505.67	2,989,765,505.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	2,458,430,100.00	2,436,590,819.97	21,839,280.03	99.1
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,383,616,400.00	2,378,235,500.00	5,380,900.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,383,616,400.00	2,378,235,500.00	5,380,900.00	99.8
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	74,813,700.00	58,355,319.97	16,458,380.03	78.0
132001	Орон нутгийн төсвөөс	74,813,700.00	58,355,319.97	16,458,380.03	78.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	301,785,300.00	2,035,980.00	299,749,320.00	0.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,572,400.00	35,000.00	3,537,400.00	1.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,537,900.00	2,000,980.00	1,536,920.00	56.6
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	294,675,000.00		294,675,000.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,760,215,400.00	2,438,626,799.97	321,588,600.03	88.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,760,215,400.00	2,304,781,829.84	455,433,570.16	83.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,584,210,300.00	2,141,066,879.84	443,143,420.16	82.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,099,269,200.00	1,751,719,385.95	347,549,814.05	83.4
210101	Үндсэн цалин	1,255,333,000.00	1,053,208,905.76	202,124,094.24	83.9
210102	Нэмэгдэл	770,563,700.00	556,567,271.09	213,996,428.91	72.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт		49,769,563.94	(49,769,563.94)	
210104	Урамшуулал	73,372,500.00	92,173,645.16	(18,801,145.16)	125.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,408,600.00	206,766,599.19	55,642,000.81	78.8
210201	Тэтгэврийн даатгал	178,437,900.00	141,848,960.11	36,588,939.89	79.5
210202	Тэтгэмжийн даатгал	20,992,700.00	17,719,271.75	3,273,428.25	84.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,496,300.00	9,871,072.26	625,227.74	94.0
210204	Ажилгүйдлийн даатгал	10,496,300.00	7,454,936.09	3,041,363.91	71.0

210205	Эрүүл мэндийн даатгал	41,985,400.00	29,872,358.98	12,113,041.02	71.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,373,600.00	44,599,699.97	12,773,900.03	77.7
210301	Гэрэл, цахилгаан	23,966,700.00	18,506,869.97	5,459,830.03	77.2
210302	Түлш, халаалт	30,153,000.00	23,325,280.00	6,827,720.00	77.4
210303	Цэвэр, бохир ус	3,253,900.00	2,167,550.00	1,086,350.00	66.6
210304	Байрны түрээс		600,000.00	(600,000.00)	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,440,100.00	13,755,620.00	3,684,480.00	78.9
210604	Урсгал засвар	17,440,100.00	13,755,620.00	3,684,480.00	78.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,338,500.00	29,568,852.73	14,769,647.27	66.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,812,400.00	240,000.00	3,572,400.00	6.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,526,100.00	29,328,852.73	11,197,247.27	72.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,380,300.00	94,656,722.00	8,723,578.00	91.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,720,500.00	81,998,772.00	8,721,728.00	90.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,659,800.00	12,657,950.00	1,850.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,005,100.00	163,714,950.00	12,290,150.00	93.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,005,100.00	163,714,950.00	12,290,150.00	93.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	155,694,100.00	143,403,950.00	12,290,150.00	92.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,311,000.00	20,311,000.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		44,650,800.00	(44,650,800.00)	
	Дотоод эх үүсвэрээр		44,650,800.00	(44,650,800.00)	
222001	Тонг төхөөрөмж		24,884,300.00	(24,884,300.00)	
223001	Бусад хөрөнгө		19,766,500.00	(19,766,500.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,760,215,400.00	2,349,432,629.84	410,782,770.16	85.1
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		295,271,108.94	(295,271,108.94)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		429,116,079.07	(429,116,079.07)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 25,226.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 16 нэр төрлийн 5,750.0 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй,
- Тайлант онд шинээр орлогод авсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 335,316.3 мянган төгрөгийн дулааны болон цэвэр усны шугамыг орлогод авахдаа 19,476.3 мянган төгрөгөөр илүү тусган бүртгэсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн

тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ¹4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **2,716.2** мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 2,716.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, биет бус хөрөнгөтэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **2,716.2** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,364.9 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 3 ажилтанд 544.7 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа үйлчилгээний зардлаас сургалтын тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардалд 2,171.5 мянган төгрөгийн сандал ширээ худалдан авч зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” Засгийн газрын 2024 оны 39 тогтоолын 4 дүгээр хавсралтын “...зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 2 дахь “Байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардалд захиргааны бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, бараа үйлчилгээний бусад, төлбөр хураамж, даатгал, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардал гэх мэт зардал багтана”, 9 дэх “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн нөхцөлийг хангах, сургалтын биет орчны батлагдсан стандартад үе шаттай нийцүүлэхэд зайлшгүй шаардлагатай ... сургалтын тоног төхөөрөмж, цэцэрлэгийн зөөлөн эдлэл, тоглоом худалдан авах, эзэмших, ашиглах, санхүүгийн түрээсийн хэлбэрээр санхүүжүүлэх зардал багтана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

¹ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Тухайн байгууллагын эзэмшилд буй 1 газрын хэмжээ нь газрын гэрчилгээнд 6207 м² гэж бүртгэгдсэн боловч санхүүгийн тайланд 6270 м² буюу зөрүүтэй бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүлээ.

Дээрх албан шаардлага зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	5,750.1	1	5,750.1			1	5,750.1				
Хөрөнгө оруулалтаар хийгдсэн дулааны болон цэвэр усны шугамыг орлогод авахдаа илүү тусган бүртгэсэн	1	19,476.3			1	19,476.3	1	19,476.3				
Дүн	2	25,226.4	1	5,750.1	1	19,476.3	2	25,226.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон	1	544.7			1	544.7					
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	2,171.5			1	2,171.5					
Биет бус хөрөнгийг бүртгэлд зөрүүтэй дүнгээр тусгасан							1	-			
Дүн	2	2,716.2			2	2,716.2	1	-			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			